



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/29/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхтуул
Утас: 261885 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn
Пийк ОМ Аудит ХХК-ийн захирал Б.Жаргалсайхан
Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	12
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа	20
5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил	20
5.2.1 Төлбөрийн акт.....	20
5.2.2 Албан шаардлага	20
5.2.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/712
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тус станц нь нүүрс, түлшний зардалд тавих дотоод хяналт сул, үйл ажиллагааны онцлогт тохирох хэвийн хорогдол тооцох журмыг боловсруулж, мөрдөөгүй, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан дах 1,522.6 сая төгрөгийн нүүрсний үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй;
- Гүйцэтгэх захирлын “Үйл ажиллагааны бус орлого хуваарилах тухай” 2025 оны А/70 дугаар тушаалаар нийт 271 ажилтанд 97.4 сая төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон;
- Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалыг тооцож, компаниас олгосон 92.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг холбогдох албан тушаалтнаар төлүүлээгүй байна.
- Харилцагчийн хоолны зардалд 9.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан; Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1, 20

дугаар зүйлийн 20.2, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.5, 15.1.3, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2025 оны 4 дүгээр тогтоолоор төрийн өмчит компаниудын удирдлага менежментээр хангах үүрэг бүхий Эрчист Монгол ХХК-ийг байгуулж, түүний харьяанд ажиллах компаниудыг нэрсийг баталсан байна.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан, компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн төлөөллийн 66.0 хувийг “Эрчист Монгол” ХХК, 34.0 хувийг Эрчим хүчний яам тус тус хэрэгжүүлэхээр баталсан.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор компанийн дүрэмд дахин өөрчлөлт оруулж, хувьцаа эзэмшигчийн эрхийн төлөөллийн 66.0 хувийг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34.0 хувийг Эрчист Монгол ХХК тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 122 дугаар тогтоолоор Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 102,000 метр квадрат талбай бүхий 6,658.0 сая төгрөгийн балансын үнэтэй газар эзэмших эрхийг данснаас хасаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдэлд шилжүүлсэн байна.

Бусад асуудал

Дулааны хоёрдугаар станц ТӨХК-ийн Турбогенератор №9-д гэмтэл гарч аваарын нөхцөл байдал үүссэн тул Эрчим хүчний сайдын А/123 дугаар тушаалаар 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн. Эрчим хүчний салбарын өндөржүүлсэн бэлэн байдлыг Эрчим хүчний сайдын А/142 дугаар тушаалаар 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл, А/255 дугаар тушаалаар 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл тус тус сунгасан байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,870,103,888.81	759,881,687.53
1.1.2	Дансны авлага	1,302,709,431.35	4,104,550,780.30
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	59,054,517.31
1.1.4	Бусад авлага	349,148,929.97	258,034,031.35
1.1.6	Бараа материал	2,201,935,368.31	2,456,020,705.86
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,723,897,618.44	7,637,541,722.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	22,581,425,726.21	21,269,099,324.19
1.2.2	Биет бус хөрөнгө	19,374,796,881.35	12,710,728,559.34
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	41,956,222,607.56	33,979,827,883.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	47,680,120,226.00	41,617,369,605.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	962,612,318.50	303,167,505.21
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		94,543,763.80
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	962,612,318.50	397,711,269.01
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	313,741,591.69	271,858,527.63
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	313,741,591.69	271,858,527.63
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,276,353,910.19	669,569,796.64
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	11,797,535,542.78	11,797,535,542.78
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,767,428,001.55	14,767,428,001.55
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	22,774,860,597.52	16,116,300,597.52
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,936,057,826.04)	(1,733,464,332.61)
2.3.11	Эздийн өмчийн дүн	46,403,766,315.81	40,947,799,809.24
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	47,680,120,226.00	41,617,369,605.88

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	37,803,973,037.62	44,210,880,601.78
2	Борлуулалтын өртөг	36,936,776,031.53	41,574,796,136.94
3	Нийт ашиг(алдагдал)	867,197,006.09	2,636,084,464.84
4	Түрээсийн орлого	40,410,545.55	29,969,090.87
5	Хүүний орлого	174,299,020.16	144,008,744.76
8	Бусад орлого	1,077,842,910.87	343,279,844.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,611,758,790.90	1,762,104,996.02
11	Санхүүгийн зардал	9,102,546.84	8,264,885.55
12	Бусад зардал	417,927,858.42	167,315,704.97
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	120,960,286.51	1,215,656,558.12
19	Орлогын татварын зардал	14,851,849.73	13,063,064.69
20	Татварын дараах ашиг (алдагдал)	106,108,436.78	1,202,593,493.43
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	106,108,436.78	1,202,593,493.43

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(3,042,166,262.82)	46,297,657,879.03
3	Залруулсан үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(3,042,166,262.82)	46,297,657,879.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	106,108,436.78	106,108,436.78
9	2024 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(2,936,057,826.04)	46,403,766,315.81
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,202,593,493.43	1,202,593,493.43
17	2025 оын 12 сарын 31-р үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	16,116,300,597.52	(1,733,464,332.61)	40,947,799,809.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	36,751,020,308.06	39,338,934,461.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	35,820,521,618.29	39,164,059,444.25
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	40,979,594.00	67,599,699.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	889,519,095.77	107,275,318.31
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,836,913,782.86	36,385,882,972.42
1.2.1	Ажиллагчдад төлсөн	11,814,468,975.75	13,530,638,904.67
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,478,544,260.00	3,958,259,244.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,273,852,569.04	15,083,793,956.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	263,165,541.05	480,103,494.53
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	994,965,650.12	358,295,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,538,201,537.56	2,636,625,323.02
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	14,018,360.00	15,130,016.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	459,696,889.34	323,036,533.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,914,106,525.20	2,953,051,489.14
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	174,299,020.16	144,008,744.76
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	174,299,020.16	144,008,744.76
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,480,501,218.77	4,207,282,435.18
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,480,501,218.77	4,207,282,435.18
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,306,202,198.61)	(4,063,273,690.42)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	607,904,326.59	(1,110,222,201.28)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,262,199,562.22	1,870,103,888.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,870,103,888.81	759,881,687.53

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	ЦЭХ-ийн орлого	м.төг	34,753,851.8	41,731,956.5	42,448,557.4	7,694,705.6	122.1	716,600.9	101.7
	ДЭХ-ийн орлого	м.төг	3,050,121.2	1,157,730.2	1,762,323.2	(1,287,798.0)	57.8	604,592.9	152.2
	ҮАБОрлого	м.төг	1,292,553.8	300,000.0	517,257.7	(775,296.1)	40.0	217,257.7	172.4
2	Нийт орлого	м.төг	39,096,526.9	43,189,686.7	44,728,138.3	5,631,611.4	114.4	1,538,451.5	103.6
3	Нийт зардал	м.төг	38,975,565.2	46,264,525.3	43,512,481.7	4,536,916.5	111.6	(2,752,043.6)	94.1
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг				-	-	-	
4	Татварын өмнөх ашиг	м.төг	120,961.6	(3,074,838.5)	1,215,656.6	1,094,694.9	1,005.0	4,290,495.1	(39.5)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	106,108.4	(3,074,838.5)	1,202,593.5	1,096,485.1	1,133.4	4,277,432.0	(39.1)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	8,967,291.5	364,218.8	10,202,833.3	1,235,541.8	113.8	9,838,614.5	2,801.3
	а/ Орлогын татварт	м.төг	14,853.2	-	13,063.1	(1,790.1)	87.9	13,063.1	
	б/ НӨАТ	м.төг	3,875,072.2	-	4,484,925.7	609,853.5	115.7	4,484,925.7	
	в/ НДШ	м.төг	3,495,476.6	-	3,987,408.4	491,931.7	114.1	3,987,408.4	
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	1,253,105.6	-	1,405,443.9	152,338.4	112.2	1,405,443.9	
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	72,855.2	72,855.2	70,039.8	(2,815.4)	96.1	(2,815.4)	96.1
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	858.2	1,200.0	1,109.1	250.9	129.2	(90.9)	92.4
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	255,070.6	290,163.6	240,843.4	(14,227.2)	94.4	(49,320.2)	83.0
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	290.0	326.0	280.0	(10.0)	96.6	(46.0)	85.9
9	Нийт цалингийн сан	м.төг	13,292,228.9	16,045,900.5	15,310,710.0	2,018,481.1	115.2	(735,190.5)	95.4
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,819.6	4,101.7	4,556.8	737.2	119.3	455.0	111.1
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.1	1.0	(0.0)	97.6	(0.1)	90.8
12	Хөрөнгө оруулалт	м.төг	2,215,170.9	3,919,600.0	3,503,100.0	1,287,929.1	158.1	(416,500.0)	89.4
13	Нийт авлага	м.төг	1,651,858.4	682,500.0	4,421,437.2	2,769,578.9	267.7	3,738,937.2	647.8
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

14	Нийт өглөг	м.төг	1,276,353.9	1,475,000.0	669,558.5	(606,795.4)	52.5	(805,441.5)	45.4
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	962,612.3	1,175,000.0	397,700.0	(564,912.3)	41.3	(777,300.0)	33.8
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	313,741.6	300,000.0	271,858.5	(41,883.1)	86.7	(28,141.5)	90.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь Улаанбаатар хотыг цахилгаан дулааны эрчим хүчээр хангах ойрын болон ирээдүйн нэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор БНМАУ, БНХАУ-ын Засгийн газартай 1958 оны 12 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан гэрээний дагуу “Толгойтын дулааны цахилгаан станц” нэртэйгээр 1960 онд үүсгэн байгуулагдаж, 2001 оны сүүлийн хагас жилээс “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчийн хувьцаат компани болсон байна. Анх ТС-35 маркийн ул ширэмт 3 зуух, АК-6 маркийн конденсацгийн 2 турбогенератортайгаар ашиглалтад орж, Толгойтын районыг цахилгаан эрчим хүчээр хангаж эхэлсэн бөгөөд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар 1970 онд БКЗ-75-39 ФБ маркийн 2 зуух, ПТ-12-35/10 маркийн 1 турбингенератораар өргөтгөснөөр суурилагдсан хүчин чадал нь 24 МВт болж конденсацын станцаас цахилгаан, дулааны эрчим хүч хослон үйлдвэрлэх цахилгаан, дулааны төв болон өргөжсөн.

Тус станц нь 2025 оны байдлаар 176.4 сая төгрөгийн усыг 19 хэрэглэгчид, 1,222.7 сая төгрөгийн уурыг 25 хэрэглэгчид, 1,367.6 сая төгрөгийн ЦЭХ-ийг 14 хэрэглэгчид нийлүүлсэн байна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК гэсэн статустай бөгөөд нэг бүрийн үнэ нь 100.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 117975355 ширхэг энгийн хувьцаатай, өмчийг 100.0 хувь төр, үүнээс Эрчим хүчний яам 70 хувь, ТӨБЗГ 30 хувийг эзэмшиж, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна.

Засгийн газрын “Эрчист Монгол ХХК байгуулах, давхардсан чиг үүргийг бууруулах тухай” 2025 оны 04 дүгээр тогтоолоор Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийг Эрчист Монгол ХХК-ийн харьяанд ажиллуулахаар тогтоож, харьяа компанийн дүрэмд зохих өөрчлөлт оруулах арга хэмжээг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан байна.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 06 дугаар тогтоолоор “Дулааны хоёрдугаар цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компанийн дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Дүрэмд компанийн үндсэн зорилтыг “Тодорхой үйлчилгээ явуулах нутаг дэвсгэртээ хэрэглэгчийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай бүрэн хангах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны дараах үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэрлэл эрхэлж, ажил, үйлчилгээ үзүүлнэ.
- Үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн ТУЗ гаргана.
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох УИХ, Засгийн газрын тогтоол, компанийн удирдлагаас баталсан дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөл орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;

- Зөрчлийн тухай хууль;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд нүүрсний зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа тул дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзсэн.

Тус компанийн Хяналтын хэлтэс нь дарга, дотоод аудитор, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, Хэмжил зүйч инженер, ГТУА-ны байцаагч гэсэн орон тоотойгоор, гүйцэтгэх захирлын 2014 оны 79 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын дүрэм", мөн оны 282 дугаар тушаалаар баталсан "Компанийн хяналтын хэлтсийн ажиллах журам"-ыг мөрдлөг болгон ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудиторын зүгээс 2025 онд нийт 14 ажил хийхээр төлөвлөж, тус компанийн ТУЗ-ийн даргаар батлуулж, 13 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 1 ажлыг 80.0 хувьтай хэрэгжүүлж нийт 98.5 хувийн хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Гүйцэтгэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны үйл явцад хяналт шалгалт хийж, 2 зөвлөмж хүргүүлсэн;
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө түүний хэрэгжилтийн бодит байдалд шалгалт хийж, 1 зөвлөмж хүргүүлсэн;
- Гадаад дотоод хэлцлүүдийн биелэлтэд шалгалт хийж 1 зөвлөмж хүргүүлсэн;
- Төрийн өмчийг түрээсээр ашиглуулсан байдал, үр дүн, түрээсийн төлбөр тогтоосон үндэслэл, ногдуулалт, төлөлтөд шалгалт хийх;
- Авлага, өглөгийн бүртгэлд шалгалт хийж, 1 зөвлөмж хүргүүлсэн;
- Цалин хөлс болон мөнгөн хөрөнгийн бүртгэлд шалгалт хийж 2 зөвлөмж хүргүүлсэн;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тухай бүр хянаж шалгасан гэх мэт.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 6,062.8 сая төгрөгөөр буюу 12.7 хувиар буурсан байна.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,870,103.9	759,881.7	(1,110,222.2)
Авлага	1,651,858.4	4,421,639.3	2,769,780.9
Бараа материал	2,201,935.3	2,456,020.7	254,085.4
Эргэлтийн бус хөрөнгө	41,956,222.6	33,979,827.9	(7,976,394.7)
Нийт хөрөнгө	47,680,120.2	41,617,369.6	(6,062,750.6)
Богино хугацаат өр төлбөр	962,612.3	397,711.3	(564,901.0)
Урт хугацаат өр төлбөр	313,741.6	271,858.5	(41,883.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	46,403,766.3	40,947,799.8	(5,455,966.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	47,680,120.2	41,617,369.6	(6,062,750.6)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, эргэлтийн бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмч данснуудад нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 759.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,110.2 сая төгрөгөөр буурахад Диспетчерийн үндэсний төв ТӨХК-аас авах авлага өссөн нь нөлөөлсөн байна. Арилжааны банкны харилцах дансанд 754.9 сая төгрөг, кассад 5.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Авлага дансны үлдэгдэл 4,421.6 сая төгрөг болж, 2,769.8 сая төгрөгөөр өсөхөд эрчим хүчний борлуулалтын 97.0 хувийг худалдан авдаг Диспетчерийн үндэсний төв ТӨХК-аас авах авлага 2,821.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.
- Нийт дансны авлагын 92.0 хувь буюу 4,067.5 сая төгрөгийн борлуулалтын авлага, 6.7 хувь буюу 295.1 сая төгрөгийн байгууллагаас авах авлага, 1.3 хувь буюу 59.1 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдэл байна.
- Бараа материалын үлдэгдэл 254.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нүүрсний үлдэгдэл 24.2 мян.тн болж өмнөх оноос 4.8 мян.тн-оор нэмэгдсэн, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 694 дугаар тогтоолоор Багануур ХХК-ийн 1 тн нүүрсний үнийг 59,091 төгрөг, 2025 оны 04 дүгээр сарын 02-ны 167 дугаар тогтоолоор 51,386 төгрөг болгон нэмсэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 33,979.8 сая төгрөг болж, өмнөх оноос 7,976.4 сая төгрөгөөр буурахад ТӨБЗГ-ын 122 дугаар тогтоолоор 6,658.6 сая төгрөгийн газар эзэмших эрхийг хассан, мөн 398 дугаар тогтоолоор 345 нэр төрлийн 107.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, устгасан нь голлон нөлөөлсөн байна.
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 397.9 сая төгрөг болж, өмнөх оноос 564.9 сая төгрөгөөр буурахад 2024 онд эхэлсэн Зуух №2, Зуух №5-ийн их засварын 603.5 сая ажлыг бүрэн гүйцэтгэж, төлбөрийг бүрэн барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчид өгөх 303.2 сая төгрөг, урьдчилж орсон орлого 94.5 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.
- Урт хугацаат зээл дансанд Засгийн газрын 2011 оны 276/300 дугаар тушаалыг үндэслэн эрчим хүчийг хэмнэх зорилгоор хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-тай 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний 271.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй, 2025 оны тайлант жилд урт хугацаат өр төлбөрөөс гэрээний дагуу 41.9 сая төгрөгийг төлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч дансны үлдэгдэл 40,947.8 сая төгрөг болж, өмнөх оноос 5,456.0 сая төгрөгөөр буурахад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 122 дугаар тогтоолоор тус компанийн эзэмших эрх бүхий 102000 метр квадрат талбай бүхий 6,658.0 сая төгрөгийн газар эзэмших эрхийг данснаас хасаж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдэлд шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Судалгааны үр дүн:

Тус станцын программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2017, 2018, 2019, 2022, 2025 онд худалдан авч, ашиглаж байгаа архив, албан хэрэг хөтлөлтийн программ, вэб сайт, цаг тохируулагч программ, вирусийн эсрэг программ, касс хоолны систем, индусофт программ v8.1 лис 1200tag Зуух№1, индусофт вэб студио программын лиценз, тоолуурын систем программ зэрэг 9 нэр төрлийн, нийт 46.6 сая төгрөгийн өртөгтэй программ хангамжууд байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3¹-т заасны дагуу компани нь санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 18 дугаар тогтоолоор 2025 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ын төлөвлөгөөг баталж, Эрчим хүчний яаманд хүргүүлсэн.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар тус төлөвлөгөөг баталж, тайлант хугацаанд дээрх зорилтот түвшнийг 2 удаа тодотгосон байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /гол нэр төрлөөр/

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК тайлант онд нийт 161.1 сая.квтц цахилгаан эрчим хүч боловсруулж, 141.7 сая.квтц-ыг түгээх, 243.7 сая.Гкал дулаан үйлдвэрлэж, түгээх төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд 166.1 сая.квтц цахилгаан эрчим хүч боловсруулсан нь төлөвлөснөөс 4.9 хувиар, 147.5 сая.квтц-ыг түгээсэн нь төлөвлөснөөс 5.8 хувиар тус тус илүү гүйцэтгэлтэй байна.

Дулаан эрчим хүч боловсруулах, түгээх ажлын гүйцэтгэл 247.4 мян.Гкал буюу төлөвлөснөөс 3.8 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний борлуулалтыг 19.4 сая.кВтц төлөвлөснөөс гүйцэтгэлээр 18.6 сая.кВтц хэрэглэж, 95.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 827.0 мянган кВтц цахилгаан эрчим хүч хэмнэж, 237.9 сая төгрөгөөр борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийт 43,189.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 46,264.5 сая төгрөгийн зардал гаргаж, 3,074.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, улсын төсөвт 10,459.7 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 44,728.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 44,143.5 сая төгрөгийн зардал гарган, төсөвт 10,202.8 сая төгрөг төвлөрүүлж, 571.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Борлуулалтын орлого төлөвлөснөөс 1,321.2 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар давж биелэхэд системийн хэрэглэгчийн ачаалал нэмэгдсэнтэй холбоотойгоор Диспетчерийн үндэсний төв ТӨХК-иас горим өндөр өгсөн, тоноглолын зогсолт буурсан нь түгээлт нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 2,752.0 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарахад дараах шалтгаанууд голлон нөлөөлсөн байна.

Үүнд:

- Тэжээлийн усны температур нэмэгдэж, уурын хувийн зарцуулалт буурсан болон нүүрсний илчлэг өндөр байгаатай холбоотойгоор нүүрсний зарцуулалт буурч төлөвлөгөөнөөс 831.1 сая төгрөг,

¹ 20.1.Захирал дараах эрх, үүрэгтэй:3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

- Нийт 34 орон тоо дутуу байгаатай холбоотойгоор цалин, НДШ-ийн зардал 891.0 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Нийт зардлын 95.5 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 4.1 хувийг ерөнхий удирдлагын, 0.4 хувийг бусад зардал эзэлж байна.

Борлуулалтын 1.00 төгрөг тутам 1.07 төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 0.97 төгрөгийг зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлөвлөгөөнд 11 ажилд 3,235.0 сая төгрөг баталж, гүйцэтгэл 100.0 хувь буюу 11 ажилд 2,891.0 сая төгрөг зарцуулж, 344.0 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Техник зохион байгуулалтын ажлын төлөвлөгөөнд 11 ажилд 335.0 сая төгрөг баталж, гүйцэтгэл 100.0 хувь буюу 11 ажилд 309.0 сая төгрөг зарцуулж, 26.0 сая төгрөг хэмнэсэн байна.

Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд 18 ажилд 350 сая төгрөг баталж, гүйцэтгэл 94.4 хувь буюу 17 ажилд 303.1 сая төгрөг зарцуулж, 46.5 сая төгрөг хэмнэсэн байна. Нийт 3,919.6 сая төгрөгийн 40 ажил төлөвлөснөөс, гүйцэтгэл 98.1 хувь буюу 39 ажилд 3,503.1 сая төгрөг зарцуулсан байна. Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд тусгасан 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хиймэл дагуулын харилцаа холбооны радио станц" худалдаж авах ажил хийгдээгүй байна.

Судалгааны үр дүн:

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу дараах судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

1. Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захиргаа, ҮЭ-ийн хороотой байгуулсан 2023-2024 оны хамтын гэрээг үндэслэн гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 21 дүгээр тушаалаар унаа, хоолны тарифыг 7.0-8.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд нийт 356.0 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг олгосон.
2. Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалыг тооцож 92.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг байгууллагаас төлсөн байна.
3. Тухайн жил сургалтын төлөвлөгөөнд 79.9 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр ХАБАЭ болон гамшгаас хамгаалах сургалтын хүрээнд 21.4 сая төгрөг, эрсдэлтэй ажлын байрны эрх олгох, сунгах сургалтад 11.9 сая төгрөг, мэргэшил дээшлүүлэх болон ажлын байрны шаардлагатай бусад сургалтад 22.3 сая төгрөг, нийт 55.6 сая төгрөг зарцуулж, 24.3 сая төгрөг хэмнэсэн байна.
4. Тайлант онд 313 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 279 орон тоотой ажилласан байна. Тус станц нь тайлант онд цомхотгол хийгээгүй, зуухан цехэд 14, түлш дамжуулах цехэд 2, турбин-хими цехэд 4, цахилгаан дамжуулах, хяналт, хэмжүүр, автоматикийн цех 6, техникийн бодлогын алба 1, захиргаа удирдлагын хэлтэс 2, санхүү бүртгэлийн хэлтэс 2, аж ахуйн хэлтэс 3 нийт 34 орон тоо дутуу ажиллаж, цалингийн зардлыг хэмнэсэн байна.
5. Хэвлэл, мэдээллийн байгууллагаар гэрээт ажил гүйцэтгүүлээгүй, гадаад томилолт арга хэмжээний зардал гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, Я.Батбаяр нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Мөнхтуул, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Т-01/30 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 36,936.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 369.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон компанийн нээлттэй, ил тод байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийсэн;
- Улирал бүр төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаж, төсвийг гүйцэтгэлд ногдохоор тайлагнан хэмнэлт, хэтрэлтийн шалтгааныг тодруулж, гүйцэтгэх удирдлагад танилцуулан, зохих арга хэмжээг авч хэвшсэн;
- Үндэсний Аудитын газрын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09/2048 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган улирал бүр биелэлтийг гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэнд нийт 0.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд тайлант онд мэдээлбэл зохих 129 мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль, тогтоомжтой нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тушаал шийдвэртэй холбоотой

Гүйцэтгэх захирлын "Үйл ажиллагааны бус орлого хуваарилах тухай" 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 172 дугаар мөрөнд тус станцад ажилладаггүй, 2023 оны Б/32 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдөж, хөдөлмөрийн харилцаа дууссан нэр бүхий ажилтанд 0.1 сая төгрөгийн орлого хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулахад дараах шаардлагыг хангаж ажиллана", 36.1.2-д "Баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг хангах", 36.1.4-д "Баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэрт тавих хяналтыг сайжруулж хавсралт, тооцооллыг зөрүүгүй бэлтгэж байх зөвлөмж зөвлөмж өглөө.

2. Хамтын гэрээтэй холбоотой

Компанийн захиргаа, ҮЭ-ийн хороотой байгуулсан 2023-2024 оны хамтын гэрээний 5.17-д "Тус компанитай ажил төрлийн холбоо бүхий бусад байгууллагын зарим ажилтныг баяр ёслол, байгууллагын ойн өдрийг нь тохиолдуулан шагнаж урамшуулж болно" гэсэн заалт нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулахад дараах шаардлагыг хангаж ажиллана" 36.1.2-т "Баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг хангах", 36.1.4-т "Баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хамтын гэрээ, хэлэлцээрийг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах зөвлөмж өглөө.

3. Тушаал шийдвэртэй холбоотой

Гүйцэтгэх захирлын "Үйл ажиллагааны бус орлого хуваарилах тухай" 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалд 20.9 сая төгрөгийг цех, алба хэлтэс, нэр бүхий ажилтнуудад хуваарилахаар шийдвэрлэсэн боловч тус тушаалын хавсралтад 12.9 сая төгрөг гэж зөрүүтэй тусгасан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-т "Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна", 95.4-т "Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4 Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны бус орлогыг ажилчдад олгох тушаалын хавсралтыг буруу бэлтгэсэн, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

4. Хөдөлмөрийн гэрээтэй талаар

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 17 дугаар тогтоолын 1-т “Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулахыг ТУЗ-ын даргад зөвшөөрсүгэй” гэж заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 1.2 дахь заалтыг бэлтгэхдээ техникийн алдаа гаргаж, “Энэхүү гэрээ нь 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаанд хүчинтэй байна” тусгасан нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байна.

Энэ нь Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина”, 36 дугаар зүйлийн 36.1-д “Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулахад дараах шаардлагыг хангаж ажиллана”, 36.1.2-д “Баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг хангах”, 36.1.4-д “Баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх” заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацааг буруу бэлтгэсэн, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тушаал шийдвэртэй холбоотой, хамтын гэрээтэй холбоотой, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой асуудлууд холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар компанийн 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан бөгөөд жилийн эцсийн аудитаар үнэлж, залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгуулахаар аудитын тайланд тусгасан.

Завсрын аудитаар нийт нийт 229.2 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 82.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, бусад асуудалд нотлох баримтыг үндэслэн жилийн эцсийн тайланд үнэлж, аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус станц нь нүүрс, түлшний зардалд тавих дотоод хяналт сул, үйл ажиллагааны онцлог тохирох хэвийн хорогдол тооцох журмыг боловсруулж, мөрдөөгүй байгааг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа

Аудитаар нийт 631.0 сая төгрөгийн 1 алдаа² илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа: "Нүүрсний илчлэг болон хаягдал нүүрс /чулуун хорогдол/" гэсэн гүйлгээний утгатай 631.0 сая төгрөгийн бодит бус хорогдол тооцож, нүүрсний үлдэгдлийг бууруулсан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 1,772.5 сая төгрөгийн 9 зөрчил² илэрсэнд, 3.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,763.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 5.5 төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,772.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 3.3 сая төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр олгосон 3.3 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Захирлын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлаар "Бэлэг дурсгалын зүйл олгох" тухай хэлэлцэж, гүйцэтгэх захирлын тушаалгүйгээр нийт ажилтнуудад "Эрчим хүчний баяр"-ыг тохиолдуулан 28.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн "Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, зардлыг бүртгэх тухай журам"-ын 6.1-д "Компанийн дансанд оруулсан орлогоос зарцуулах эрх, зарцуулагдах

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

тоо хэмжээ нь Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр зарцуулагдана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин бэлэг дурсгалын зүйл худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Захирлын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэх захирлын “Үйл ажиллагааны бус орлогот хуваарилах тухай” 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/70 дугаар тушаалаар нийт 271 ажилтанд 97.4 сая төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн “Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, зардлыг бүртгэх журам”-ын 6.2-д “Үндсэн үйл ажиллагааг идэвхжүүлэхтэй холбоотой зарлагдсан болзолт уралдааны зардал, идэвх санаачилгатай оролцсон нэгж, хамт олон, ажилтнуудыг шагнах”, 6.10.1-д “Үр бүтээлтэй ажилласан бригад, хамт олныг урамшуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийт ажилчдад урамшууллыг хавтгайруулан олгодог зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин гүйцэтгэх захирлын 2025 оны А/69, А/89 дугаар тушаалаар компанийн ажилтан бус дотоодын цэргийн алба хаагчдад 1.9 сая төгрөгийн урамшуулал олгосон, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК болон Дотоодын цэргийн 05 дугаар ангийн Хамгаалалтын 07 дугаар салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэхтэй холбоотой өдөрлөгийн зардалд 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчин өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, зориулалтын бус, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар тайлант оны ажил мэргэшлийн аваргад нэр дэвшсэн 15 ажилтан тус бүр 0.5 сая төгрөгөөр хавтгайруулан шагнаж, нийт 7.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хууль зөрчин хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Харилцагчийн хоолны зардалд 9.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3-т “Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, зориулалтын бус, үр ашиггүй зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6. Тус станц нь нүүрс, түлшний зардалд тавих дотоод хяналт сул, үйл ажиллагааны онцлогт тохирох хэвийн хорогдол тооцох журмыг боловсруулж, мөрдөөгүй, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан дах 1,522.6 сая төгрөгийн нүүрсний үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нүүрсний үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 7. Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалыг тооцож, компаниас олгосон 92.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг холбогдох албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдлагын буруу шийдвэрээр компанид учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй зөрчлийг арилгаж, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/-т албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: Аморе ХХК-иас 2016 онд худалдан авсан одоогийн ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн улмаас ашиглах боломжгүй, хийц хэсэг нь таарахгүй болсон 5.5 сая төгрөгийн 3 нэр төрлийн 3 ширхэг хөрөнгө үнэ цэнэгүй болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэсэн заалт болон УСННБОУС-2 Бараа материал стандартын заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалд тавих хяналтыг сайжруулж, тус станцад ашиглах боломжгүй болсон хөрөнгүүдийн борлуулах, данснаас хасах эсэхийг судлан шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
"Нүүрсний илчлэг болон хаягдал нүүрс /чулуун хорогдол/" гүйлгээний утгатай 631.0 сая төгрөгийн бодитой бус хорогдол тооцож нүүрсний үлдэгдлийг бууруулсан байна.	1	630,990.0					1	630,990.0				
Дүн	1	630,990.0	-	-	-	-	1	630,990.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 3.3 сая төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.	1	3,285.0	1	3,285.0								
2	Захирлын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлаар "Бэлэг дурсгалын зүйл олгох" тухай хэлэлцэж, гүйцэтгэх захирлын тушаалгүйгээр нийт ажилтнуудад "Эрчим хүчний баяр"-ыг тохиолдуулан 28.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг олгосон байна.	1	28,137.0			1	28,137.0						
3	Захирлын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэх захирлын "Үйл ажиллагааны бус орлогот хуваарилах тухай" 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/70 дугаар тушаалаар нийт	1	97,350.0			1	97,350.0						

**Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	271 ажилтанд 97.4 сая төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон байна.												
4	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин гүйцэтгэх захирлын 2025 оны А/69, А/89 дугаар тушаалаар компанийн ажилтан бус дотоодын цэргийн алба хаагчдад 1.9 сая төгрөгийн урамшуулал олгосон, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК болон Дотоодын цэргийн 05 дугаар ангийн Хамгаалалтын 07 дугаар салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэхтэй холбоотой өдөрлөгийн зардалд 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	5,495.0			1	5,495.0						
5	Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар тайлант оны ажил мэргэшлийн аваргад нэр дэвшсэн 15 ажилтан тус бүр 0.5 сая төгрөгөөр хавтгайруулан шагнаж, нийт 7.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	7,500.0			1	7,500.0						
6	Харилцагчийн хоолны зардалд 6.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	9,938.1			1	9,938.1						
7	Тус станц нь нүүрс, түлшний зардалд тавих дотоод хяналт сул, үйл ажиллагааны онцлогт тохирох хэвийн хорогдол тооцох журмыг боловсруулж, мөрдөөгүй, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан дах 1,522.6 сая төгрөгийн нүүрсний үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй байна.	1	1,522,615.8			1	1,522,615.8						
8	Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалыг тооцож, компаниас олгосон 92.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг холбогдох албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	1	92,648.1			1	92,648.1						
9	2016 онд Аморе ХХК-иас худалдан авсан одоогийн ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн улмаас ашиглах боломжгүй, хийц хэсэг нь таарахгүй болсон 5.5 сая төгрөгийн 3 нэр төрлийн 3 ширхэг хөрөнгүүд үнэ цэнэгүй болсон байна.	1	5,500.0					1	5,500.0				
	Нийт дүн	9	1,772,469.0	1	3,285.0	7	1,763,684.0	1	5,500.0	-	-	-	-

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	"Үйл ажиллагааны бус орлого хуваарилах тухай" Гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 172 дугаар мөрөнд тус станцад ажилладаггүй, 2023 оны Б/32 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдөж, хөдөлмөрийн харилцаа дууссан нэр бүхий ажилтанд 0.1 сая төгрөгийн орлого хуваарилахаар шийдвэрлэсэн.	1	90.0			1	90.0
2	"ДЦС-2" ТӨХК-ийн захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан 2023-2024 оны хамтын гэрээний 5.17-д "Тус компаниаар ажил төрлийн холбоо бүхий бусад байгууллагын зарим ажилтныг баяр ёслол, байгууллагын ойн өдрийг нь тохиолдуулан шагнаж урамшуулж болно" гэсэн заалт нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцээгүй	1	-			1	-
3	"Үйл ажиллагааны бус орлого хуваарилах тухай" Гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалд 20.1 сая төгрөгийг цех, алба хэлтэс, нэр бүхий ажилтнуудад хуваарилахаар шийдвэрлэсэн байхад тус тушаалын 1 дүгээр хавсралтад 82.6 сая төгрөгийн хүүгийн орлогоос 69.7 сая төгрөгийг байгууллагад үлдээж, 12.9 сая төгрөгийг хуваарилна гэж зөрүүтэй тусгасан.	1	-	1	-		
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 17 дугаар тогтоолын 1-т "Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулахыг ТУЗ-ын даргад зөвшөөрсүгэй" гэж заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 1.2 дахь заалтыг бэлтгэхдээ техникийн алдаа гаргаж, "Энэхүү гэрээ нь 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаанд хүчинтэй байна" тусгасан нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байна.	1	-	1	-		
Нийт дүн		4	90.0	2	-	2	90.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 158/А0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/29/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 3,285,000.00 /Гурван сая хоёр зуун наян таван мянган/ төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр олгосон 3,285,000.00 /Гурван сая хоёр зуун наян таван мянган/ төгрөгийг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн нягтлан бодогч /Ц.Азжаргал/-аар төлүүлж, Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/-д даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Akr\2026\0316.SAG-19.Docx

1526009179



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 686/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлаар "Бэлэг дурсгалын зүйл олгох" тухай хэлэлцэж, гүйцэтгэх захирлын тушаалгүйгээр нийт ажилтнуудад "Эрчим хүчний баяр"-ыг тохиолдуулан 28,137,000.00 /Хорин найман сая нэг зуун гучин долоон мянган/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн "Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, зардлыг бүртгэх тухай журам"-ын 6.1-д "Компанийн дансанд оруулсан орлогоос зарцуулах эрх, зарцуулагдах тоо хэмжээ нь Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр зарцуулагдана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин бэлэг дурсгалын зүйл худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

ATA16007
9025001411

Z: Alban Shaardlaga 2026/0316 SAG-32 Docx

1526180864



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 687/А0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/29/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэх захирлын "Үйл ажиллагааны бус орлогот хуваарилах тухай" 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/70 дугаар тушаалаар нийт 271 ажилтанд 97,350,000.00 /Ерэн долоон сая гурван зуун тавин мянган/ төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн "Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, зардлыг бүртгэх журам"-ын 6.2-д "Үндсэн үйл ажиллагааг идэвхжүүлэхтэй холбоотой зарлагдсан болзолт уралдааны зардал, идэвх санаачилгатай оролцсон нэгж, хамт олон, ажилтнуудыг шагнах", 6.10.1-д "Үр бүтээлтэй ажилласан бригад, хамт олныг урамшуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй бол албан шаардлага өгөх үндэслэл болно" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийт ажилчдад урамшууллыг хавтгайруулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 688/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026/29/ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин гүйцэтгэх захирлын 2025 оны А/69, А/89 дугаар тушаалаар компанийн ажилтан бус дотоодын цэргийн алба хаагчдад 1,900,000.00 /Нэг сая есөн зуун мянган/ төгрөгийн урамшуулал олгосон, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК болон Дотоодын цэргийн 05 дугаар ангийн Хамгаалалтын 07 дугаар салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэхтэй холбоотой өдөрлөгийн зардалд 3,595,000.00 /Гурван сая таван зуун ерэн таван мянган/ төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6 “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчин өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, зориулалтын бус, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 689/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар тайлант оны ажил мэргэшлийн аваргад нэр дэвшсэн 15 ажилтан тус бүр 500,000.00 /Таван зуун мянган/ төгрөгөөр хавтгайруулан шагнаж, нийт 7,500,000.00 /Долоон сая таван зуун мянган/ төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн хууль зөрчин хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 690/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцагчийн хоолны зардалд 9,938,152.18 /Есөн сая есөн зуун гучин найман мянга нэг зуун тавин хоёр төгрөг арван найман мөнгө/-ийг зориулалт бусаар зарцуулсан байна.


Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3-т "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, зориулалтын бус, үр ашиггүй зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 691/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус станц нь нүүрс, түлшний зардалд тавих дотоод хяналт сул, үйл ажиллагааны онцлогт тохирох хэвийн хорогдол тооцох журмыг боловсруулж, мөрдөөгүй, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан дах 1,522,615,772.37 /Нэг тэрбум таван зуун хорин хоёр сая зургаан зуун арван таван мянга долоон зуун далан хоёр төгрөг гучин долоон мөнгө/-ний нүүрсний үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй нь албан шаардлага өгөх үндэслэл болно гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Нүүрсний үлдэгдлийг тооллогоор баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-32.Docx

1526180874



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 692/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалыг тооцож, компаниас олгосон 92,648,108.00 /Ерэн хоёр сая зургаан зуун дөчин найман мянга нэг зуун найман/ төгрөгийн нөхөн төлбөрийг холбогдох албан тушаалтнаар төлүүлээгүй байна.


Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Удирдлагын буруу шийдвэрээр компанид учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт/ даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 693/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын "Үйл ажиллагааны бус орлого хуваарилах тухай" 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалд 20,930,000.00 /Хорин сая есөн зуун гучин мянган/ төгрөгийг цех, алба хэлтэс, нэр бүхий ажилтнуудад хуваарилахаар шийдвэрлэсэн боловч тус тушаалын хавсралтад 12,900,000.00 /Арван хоёр сая есөн зуун мянган/ төгрөг гэж зөрүүтэй тусгасан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-т "Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна", 95.4-т "Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4 Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны бус орлогыг ажилчдад олгох тушаалын хавсралтыг буруу бэлтгэсэн, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9906109
ATA16097
9025001411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-32.Docx

1526180878



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 694/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/29/МА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 17 дугаар тогтоолын 1-т "Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулахыг ТУЗ-ын даргад зөвшөөрсүгэй" гэж заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 1.2 дахь заалтыг бэлтгэхдээ техникийн алдаа гаргаж, "Энэхүү гэрээ нь 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаанд хүчинтэй байна" тусгасан нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байна.


Энэ нь Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина", 36 дугаар зүйлийн 36.1-д "Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулахад дараах шаардлагыг хангаж ажиллана", 36.1.2-д "Баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг хангах", 36.1.4-д "Баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх" заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны ээм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацааг буруу бэлтгэсэн, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Минжинхүү/, нягтлан бодогч /Ц.Азжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-32.Docx

1526180880